НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 12 өдөр Дугаар 19 Улаанбаатар хот

Нийслэлийн өмчид 14 барилга байгууламжийг
бүртгэн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 118 дугаар тогтоол, 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/627 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон нийт 24,945,204,348 /хорин дөрвөн тэрбум есөн зуун дөчин таван сая хоёр зуун дөрвөн мянга гурван зуун дөчин найман/ төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 барилга байгууламжийг хавсралт ёсоор нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА Р.ДАГВА

1110100042

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 02 дугаар сарын 12-ны
өдрийн 19 дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ 14 БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1.	115 дугаар цэцэрлэгийн 150 ортой өргөтгөлийн барилга	Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо, дүүргийн ЭМТ-ийн баруун хойно	2016	1,220,534,037	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
2.	251 дүгээр цэцэрлэгийн барилга	Баянзүрх дүүргийн 24 дүгээр хорооны цогцолбор байрны урд	2018	1,158,381,511	АНУ-ын буцалтгүй тусламж, Улсын төсвийн хөрөнгө оруулалт
3.	127 дугаар сургуулийн барилга	Баянзүрх дүүргийн 21 дүгээр хороо, Дарь-Эх, ШШБЕГ-ын 461-р ангийн баруун талд	2015	3,810,700,000	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
4.	Аврах, гал унтраах 74-р ангийн контор, гаражийн цогцолбор	Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороо, Хуурай мухрын ам	2018	1,954,990,000	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
5.	6 авто машины гараж-конторын барилга	Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороо, Бэлхи	2015	768,126,082	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт
6.	149 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга	Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хороо, Сөүлийн гудамж	2017	515,731,739	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт
7.	Ахмад хөгжлийн төвийн барилга	Баянгол дүүргийн 6 дугаар хороо, 10 дугаар хороолол	2018	607,784,255	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт
8.	Баянгол Засаг даргын Тамгын газрын өргөтгөлийн барилга	Баянгол дүүргийн 4 дүгээр хороо, ЗДТГ-ын зүүн талд	2016	1,999,829,473	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт
9.	228 дугаар цэцэрлэгийн барилга	Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, Нефтийн байрны дунд	2018	1,346,598,390	Улсын төсвийн хөрөнгө оруулалт

НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 31 өдөр Дугаар 40 Улаанбаатар хот

Сайжруулсан түлшний агуулахын 3 барилгыг
нийслэлийн өмчид бүртгэн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг,Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчид хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам"-ын 3.2.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/1127 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон нийт 2,234,067,507 /хоёр тэрбум хоёр зуун гучин дөрвөн сая жаран долоон мянга таван зуун долоон/ төгрөгийн өртөг бүхий хавсралтад дурдсан сайжруулсан түлшний агуулахын 3 барилгыг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д үүрэг болгосугай.

ДАРГА Р.ДАГВА

1110100097

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 40 дүгээр тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	Сайжруулсан түлшний агуулахын барилга байгууламж	СХД, 1 дүгээр хороо, Орбит станцын урд	2019	748,253,000	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
2	Сайжруулсан түлшний агуулахын барилга байгууламж	СХД, 2 дугаар хороо, Нарангийн голын эцсийн буудлаас хойш	2019	748,000,000	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
3	Сайжруулсан түлшний агуулахын барилга байгууламж	ХУД, 10-р хороо, Нисэхийн 20000 м3/хон цэвэрлэх байгууламжийн баруун талд	2019	737,814,507	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
	ДҮН			2,234,067,507	

.....oOo.....

НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 31 өдөр Дугаар 42 Улаанбаатар хот

Нийтийн бие засах газрын барилгыг
нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3.м дэх заалт, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, 79 дүгээр зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/1469 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй, хавсралтад дурдсан 29,676,300 /хорин есөн сая зургаан зуун далан зургаан мянга гурван зуун/ төгрөгийн үнэ бүхий нийтийн бие засах газрын барилгыг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын алба /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА Р.ДАГВА

111010010З

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 41 дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглаг ан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд үнэ /төгрөг/	Байгуулсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/
Барилга								
1.	Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны арван байрны оршин суугчдын нийтийн бие засах газар	4	ш	1	29,676,300	29,676,300	25,224,855	4,451,445
НИЙТ					29,676,300	29,676,300	25,224,855	4,451,445

.....oOo.....

НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 31 өдөр Дугаар 42 Улаанбаатар хот

Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсийн 2 барилгыг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчид хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/1310 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2020 оны 02-07-383/157 дугаар дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй нь тогтоогдсон, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар цагдаагийн хэлтсийн шинэ барилга барих болсонтой холбогдуулан Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсийн данс бүртгэлд бүртгэлтэй, нийт 144 724 336.98 /нэг зуун дөчин дөрвөн сая долоон зуун хорин дөрвөн мянга гурван зуун гучин зургаан төгрөг, ерэн найман мөнгө/ төгрөгийн өртөг бүхий хавсралтад дурдсан 2 барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА Р.ДАГВА

1110100099

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 22 дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиг-ласан жил	Нэгжийн үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ /төгрөг/	Данснаас хасах үндэслэл
1.	Эрүүлжүүлэх байрны барилга	Налайх дүүргийн 2 дугаар хороо	17	133 633 727.33	6 681 686.4	126 952 040,93	НИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 9/36 дугаар тогтоолоор Цагдаагийн хэлтсийн шинэ барилга баригдахаар Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад орж батлагдсан
2.	Автомашины гараш	Налайх дүүргийн 2 дугаар хороо	27	11 090 609.65	1 232 289.96	9 858 319.68	
НИЙТ ДҮН				144 724 336.98	7 913 976.36	136 810 360.62	

.....oOo.....

НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 09 өдөр Дугаар 51 Улаанбаатар хот

100 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг
нийслэлийн өмчид бүртгэн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/1303 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон нийт 1,512,546,325 /нэг тэрбум таван зуун арван хоёр сая таван зуун дөчин зургаан мянга гурван зуун хорин таван/ төгрөгийн өртөг бүхий 100 дугаар цэцэрлэгийн 150 ортой өргөтгөлийн барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА Р.ДАГВА

1110100122

НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 09 өдөр Дугаар 54 Улаанбаатар хот

Хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3."м", 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/1525 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй 23,932,488 /хорин гурван сая есөн зуун гучин хоёр мянга дөрвөн зуун наян найман/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий нэгдүгээр хавсралтад дурдсан барилга, байгууламжийг тус дүүргийн Дотоод аудитын албаны балансад, 44 дүгээр цэцэрлэгийн балансад бүртгэлтэй нийт 434,926,370. 86 /дөрвөн зуун гучин дөрвөн сая есөн зуун хорин зургаан мянга гурван зуун далан төгрөг наян зургаан мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хоёрдугаар хавсралтад дурдсан барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийг мөн тус дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн балансад тус тус шилжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /С.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА Р.ДАГВА

1110100121

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 34 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

№	Шилжүүлэх эд хөрөнгийн нэр	Байршил	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл /2020,03,30/	Үлдэгдэл үнэ
1	Сүрлэн байшин	БХД. 1 дүгээр хороо	17	ш	1	23,932,488.00	23,932,488.00	3,739,451.25	20,193,036.75
	Шилжүүлэх барилга, байгууламжийн дүн					23,932,488.00	23,932,488.00	3,739,451.25	20,193,036.75

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр
сарын 09-ний өдрийн 54 дугаар тогтоолын
хоёрдугаар хавсралт

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

№	Шилжүүлэх эд хөрөнгийн нэр	Байршил	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл /2020,03,30/	Үлдэгдэл үнэ
1	Цэцэрлэгийн барилга	БХД. 1 дүгээр хороо	24	ш	1	425,257,100.86	425,257,100.86	22,148,807.34	403,108,293.52
2	Бохирын шугам		16	у/м	38	242,110.00	9,200,180.00	718,764.06	8,481,415.94
3	Торон хашаа		6	у/м	135	3050.67	411,840.00	85,800.00	326,040.00
4	Мод		10	ш	5	7,450.00	37,250.00		37,250.00
	Шилжүүлэх хөрөнгийн дүн						434,906,370.86	22,953,371.40	411,952,999.46

НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 09 өдөр Дугаар 65 Улаанбаатар хот

"Бизнес инкубатор сургалт үйлдвэрлэлийн төв"-ийн барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дах хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 3.2.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/1085 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1."Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл 1"-ийн хүрээнд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон 4,797,381,612.31 /дөрвөн тэрбум долоон зуун ерэн долоон сая гурван зуун наян нэгэн мянга зургаан зуун арван хоёр төгрөг гучин нэгэн мөнгө/ төгрөгийн өртөг бүхий "Бизнес инкубатор сургалт үйлдвэрлэлийн төв"-ийн барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/ -д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА Р.ДАГВА

1110100124

НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 30 одор Дугаар 59 Улаанбаатар хот

Хувьчлалын жагсаалтаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 32/29, 2017 оны 2/24, 2018 оны 20/21 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/1973 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1.Нийслэлийн өмчөөс 2015-2018 онд хувьчлагдах жагсаалтад батлагдсан хавсралтад дурьдсан барилга байгууламжийг өмч хувьчлалын жагсаалтаас хассугай.

2.Хувьчлалын жагсаалтаас хасагдаж буй барилга байгууламжийн эзэмшилт ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 32/29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан жагсаалтын 16, 2017 оны 2/24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан жагсаалтын 1, 4, 2018 оны 20/21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан жагсаалтын 8-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Р.ДАГВА

1110100152

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 29 дүгээр тогтоолын хавсралт

ХУВЬЧЛАЛЫН ЖАГСААЛТААС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД

№	Эд хөрөнгийн нэр	Хувьчлах НИТХ-ын тогтоол	Жагсаалтаас хасах үндэслэл
1	ХУД-ийн 13-р хорооны Захирагчийн ажлын албаны 2 барилга	2015 оны 32/29	Нээлттэй дуудлагын худалдаагаар 11 удаа зарласан боловч оролцогчийн санал ирээгүй.
2	БЗД-ийн 9-р хорооны хуучин барилга	2017 оны 02/24	Баянзүрх дүүргийн 167 дугаар цэцэрлэгийн өргөтгөл барих зориулалтаар газрыг ашиглах хүсэлт гаргасан бөгөөд энэхүү асуудлыг НӨХК-ын 2020.02.07-ны өдрийн хурлаар хэлэлцэж хүсэлтийг дэмжсэн болно.
3	БЗД-ийн Цагдаагийн 3-р хэлтсийн Шар хадны хэсгийн хуучин барилга	2018 оны 20/21	
4	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газрын байр	2017 оны 02/24	"Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ нь албан конторын зориулалтаар ашигладаг бөгөөд хувьчлагдсан тохиолдолд шилжүүлэн байршуулах ажлын байргүй болно.

НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 30 өдөр Дугаар 60 Улаанбаатар хот

Хувьчлалын арга хэлбэр тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Жагсаалт батлах тухай" 20/21 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/862 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1.Нийслэлийн өмчөөс хувьчлагдах зарим барилга байгууламжийн хувьчлалын арга хэлбэрийг хавсралтаар баталсугай.

2.Хувьчлах барилга байгууламжийн үнийг бодитойгоор тогтоож, холбогдох хууль журмын дагуу хувьчлах ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Хууль эрх зүй, хяналт үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Анхбаяр/-д даалгасугай.

ДАРГА Р.ДАГВА

1110100143

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 60 дугаар тогтоолын хавсралт

ХУВЬЧЛАЛЫН АРГА ХЭЛБЭР ТОГТООСОН
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

№	Байршил	Хувьчлах барилга байгууламж	Хувьчлалын арга хэлбэр
1	Чингэлтэй дүүргийн 5-р хороо	Баруун сэлбэ үйлчилгээний төвийн "Ж" блокийн 1220 м^2 талбай бүхий байр	"Улаанбаатар радио" ХХК-д Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн дагуу санал болгон хувьчлах
2	Багануур дүүргийн 2-р хороо	Хорооны хуучин барилга	Нээлттэй дуудлагын худалдаа

НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 30 өдөр Дугаар 61 Улаанбаатар хот

Өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн
барилгыг нийслэлийн өмчид бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчид хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам"-ын 3.2.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/1717 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон 1 754 789 848 /нэг тэрбум долоон зуун тавин дөрвөн сая долоон зуун наян есөн мянга найман зуун дөчин найм/ төгрөгийн өртөг бүхий Өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА Р.ДАГВА

1110100153

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 30-ны
өдрийн 67 дүгээр тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	Өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн барилга байгууламж	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны цогцолбор байрны зүүн талд	2019	1,754,789,848	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ДҮН				**1,754,789,848**	

НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 30 одор Дугаар 62 Улаанбаатар хот

Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 "м", 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/94 дүгээр тушаал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/1855 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори "Ирээдүй" цогцолбор сургуулийн балансад бүртгэлтэй нийт 5,670,706,900 /таван тэрбум зургаан зуун далан сая долоон зуун зургаан мянга есөн зуу/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий нэгдүгээр хавсралтад дурдсан барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийг "Хөгжил" цогцолбор сургуулийн балансад, нийт 5,721,582,243 /таван тэрбум долоон зуун хорин нэгэн сая таван зуун наян хоёр мянга хоёр зуун дөчин гурав/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хоёрдугаар хавсралтад дурдсан барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийг "Өнөр" цогцолбор сургуулийн балансад тус тус шилжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА Р.ДАГВА

1110100157

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 30-ны
өдрийн 62/дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН "ХӨГЖИЛ" ЦОГЦОЛБОР СУРГУУЛЬД
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

№	Шилжүүлэх эд хөрөнгийн нэр	Байршил	Ашиглаасан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл /2019.12.31/	Үлдэгдэл үнэ
1	Барилга 1-р бага сургууль	СХД. 12-р хороо	35	м^2	3650	757,520.14	2.764.948.493	89,191,886.88	2,675,756,606.12
2	Цахилгааны утас 1-р бага		35	ш	1	32,184,000	32,184,000	1,609,200	30,574,800
3	Сантехник 1-р бага		35	ш	1	43,186,000	43,186,000	3,926,000.04	39,259,999.96
Барилга, байгууламжийн нийт дүн							**2,840,318,493**	94,727,086.92	2,745,591,406.08
1	Хашаа	СХД. 12-р хороо	35	ш	150	51,088.53	7,663,280	1,277,213,28	6,386,066.72
2	Ногооны хашаа		35	ш	40	10,925.25	437,010	54,626.28	382,383.72
3	Зүлэгжүүлсэн талбай		35	м^2	150	11,124.13	1,668,620	556,206.72	1,112,413.28
4	Бут сөөг		35	ш	4	5,100	20,400		20,400
5	Навчит мод		35	ш	154	7,450	1,147,300		1,147,300
6	Бетон зам		35	м^2	125	316,320	39,540,000		39,540,000
Нийтийн эзэмшлийн нийт дүн							**50,476,610**	1,888,046.28	48,588,563.72

1	**Барилга 1-р дунд сургууль**	СХД. 13-р хороо	35	м^2	3650	731,020.70	2,668,225,552	88,940,851.68	2,579,284,700.32
2	Цахилгааны утас 1-р дунд		35	ш	1	23,040,000	23,040,000	1,152,000	21,888,000
3	Сантехник 1-р дунд		35	ш	1	36.270.000	36.270.000	3,627,000	32,643,000
Барилга, байгууламжийн нийт дүн							**2,727,535,552**	93.719.851.68	2,633.815,700.32
1	Хашаа	СХД. 13-р хороо	35	ш	150.5	47,427.44	7,137,830	1,189,638.36	5,948,191.64
2	Шилмүүст мод		35	ш	3	39,070	117,210		117,210
3	Навчит мод		35	ш	185	7,450	1,378,250		1,378,250
4	Бетон зам		35	м^2	125	334,113.04	41,764,130		41,764,130
5	Сүүдрэвч		8	ш	2	106,480	212,960	35,493.36	177,466.64
6	Усан оргилуур		8	ш	1	301,365	301,365	100,455	200,910
7	Зүлэгжүүлсэн талбай		35	м^2	150	9,763.33	1,464,500	488,166.72	976,333.28
Нийтийн эзэмшлийн нийт дүн							**52,376,245**	1,813,753.44	50,562,491.56
	Шилжүүлэх барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн нийт дүн						**5,670,706,900**	192,148,738.32	5,478,558,161.68

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 30-ны
өдрийн 62 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН "ӨНӨР" ЦОГЦОЛБОР СУРГУУЛЬД
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

№	Шилжүүлэх эд хөрөнгийн нэр	Байршил	Ашиглаа	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл /2019.12.31/	Үлдэгдэл үнэ
1	Барилга 3-р бага сургууль	СХД. 17 дугаар хороо	34	м^2	3650	726,226.56	2,650,726,950	88,357,565.04	2,562,369,384.96
2	Цахилгааны утас 3-р бага		34	ш	1	10,454,400	10,454,400	475,200	9,979,200
3	Сантехник 3-р бага		34	ш	1	32,461,000	32,461,000		32,461,000
Барилга, байгууламжийн нийт дүн							**2,693,642,350**	88,832,765	2,604,809,585
1	Зүлэгжүүлсэн талбай	СХД. 17 дугаар хороо	28	м^2	100	46,176.60	4,617,660	1,539,219.96	3,078,440.04
2	Бут сөөг		28	ш	30	16,490	494,700		494,700
3	Мод шилмүүст		28	ш	2	468,840	937,680		937,680
4	Мод навчит		28	ш	62	14,779.84	916,350		916,350
5	Зам бетон		28	м^2	125	340,834.80	42,604,350	7,100,724.96	35,503,625.04
6	Хөл бөмбөгийн талбай		9	ш	1	101,347,790	101,347,790	7,795,983.81	93,551,506.16
7	Хашаа		33	ш	1	7,491,600	7,491,600	1,248,600	6,243,000
Нийтийн эзэмшлийн нийт дүн							**158,410,130**	17,684,528.76	140,725,601.24
1	Барилга 2-р дунд сургууль	СХД.	34	м^2	3650	747,931.86	2,729,951,273	88,062,944.28	2,641,888,328.72

2	**Цахилгааны утас 2-р дунд**	**16 дугаар хороо**	**34**	**ш**	**1**	**19,800,000**	**19,800,000**	**990,000**	**18,810,000**
3	Сантехник 2-р дунд		34	ш	1	46,046,000	46,046,000		46,046,000
Барилга, байгууламжийн нийт дүн							**2,795,797,273**	89.052.944	2,706,744,329
1	Хашаа	СХД. 16 дугаар хороо	34	ш	149.5	50,424.21	7.538.420	1.256.403.36	6.282.016.64
2	Зүлэгжүүлсэн талбай		25	$м^2$	100	17,716.90	1,771,690	590.563.32	1,181,126.68
3	Навчит мод		25	ш	56	12,771.43	715,200		715,200
4	Бетон зам		25	$м^2$	125	509,657.44	63,707,180	10,617,863.28	53,089,316.72
Нийтийн эзэмшлийн нийт дүн							**73,732,490**	12,464,830	61,267,660
	Шилжүүлэх барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн нийт дүн						**5,721,582,243**	208,035,067.76	5,513,547,175.24

НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 30 өдөр Дугаар 03 Улаанбаатар хот

Агуулахын байрыг акталж, нийслэлийн
өмчийн бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4.2 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/1851 дүгээр албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 80 дугаар ангийн барилга шинээр баригдаж ашиглалтад орсонтой холбогдуулан суурин дээр нь байсан 2,135,700 /хоёр сая нэг зуун гучин таван мянга долоон зуу/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад дурдсан агуулахын байрыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА Р.ДАГВА

1110100160

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 30-ны
өдрийн 63 дугаар тогтоолын хавсралт

АКТАЛЖ. НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг /2019.12.31/	Акталж данснаас хасах үндэслэл
1	Агуулахын байр	1971	2,135,700	2,135,700	-	Мэргэжлийн хяналтын Улсын байцаагчийн 2013 оны 02-07-87/1165 дүгнэлт, Гал түймэр унтраах, аврах 80 дугаар ангийн барилга шинээр баригдсан

НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 30 өдөр Дугаар 64 Улаанбаатар хот

Гал түймэр унтраах, аврах 80 дугаар ангийн
барилгыг нийслэлийн өмчид бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 "м", 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.2 "б", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/1851 дүгээр албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон нийт 1,820,932,171 /нэг тэрбум найман зуун хорин сая есөн зуун гучин хоёр мянга нэг зуун далан нэг/ төгрөгийн өртөг бүхий Гал түймэр унтраах, аврах 80 дугаар ангийн барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА Р.ДАГВА

1110100162